

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Эрдэм шинжилгээний бичиг

Боть XLI (483)

Улаанбаатар

2017

ОРЧИН ЦАГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ЗӨВ БИЧИХ ДҮРМИЙН ЗАРИМ АСУУДАЛД

Б.Мөнгөнцэцэг

Түлхүүр үг: журамласан үгс, толь бичиг, зөрүүтэй үг, журамласан толь

Хүн төрөлхтний харилцааны хэрэглүүр болох хэл нь аман ярианы хэл, бичгийн хэл гэсэн хоёр үндсэн хэлбэрээр илэрдэг. Аливаа улс үндэстний нэгдмэл байхын нэг чухал үндэс нь нийтээр баримтлах бичгийн хэлний хэм хэмжээ байдаг. Үүнд зөв бичих дүрэм хийгээд зүй тогтлын дагуу найруулан бичих ёс хамаарна.

Бид энэхүү өгүүлэлдээ өнөөдөр манай улсад бүх нийтээр хэрэглэж буй кирил үсгийн зөв бичих дүрмийн үндсэн үзэл баримтлал, хэрхэн засан сайжруулах тухайд эрдэмтэн судлаачдын санал дүгнэлт, уг дүрмийг даган мөрдөх явцад үүссэн тулгамдсан асуудлууд, тэдгээрийг тухай бүр шийдвэрлэж ирсэн үйл явцад дүн шинжилгээ хийхийг зорилоо.

Түүх сөхөж үзвэл, 1941 оны тавдугаар сарын 9-ний өдөр БНМАУ-ын Сайд нарын зөвлөл, МАХН-ын Төв хорооны тэргүүлэгчдийн хамтарсан 25/27 хурлаас “Орос үсэг дээр үндэслэсэн монголын шинэ үсгийг батлах тухай” тогтоол баталснаас хойш эдүгээ 76 жил өнгөрчээ. Аливаа бичиг үсгийг хэрэглээнд хэвшүүлэхийн тулд нийтээр дагаж мөрдөх нэгдмэл дүрэмтэй болох буюу зөв бичих хэм хэмжээг тогтоохын тулд зөв бичих дүрмийг боловсруулан хэрэглэдэг.

Монгол хэлний үгийн сангийн хэдэн мянган үгийн бичлэгийг жигдэлж нэгэн мөр болгохын зэрэгцээ олон нийтийн бичиг үсгийн боловсролыг сайжруулах зорилгоор 1951 онд Ц.Дамдинсүрэн, Я.Цэвэл нар “Үсгийн дүрмийн зөв бичих толь”, 1962 онд С.Мөөмөө “Зөв бичих дүрмийн толь”, 1974 онд Х.Далхжав, Ц.Цэрэнчимэд нар “Зөв бичих зүйн толь бичиг”, 1983 онд Ц.Дамдинсүрэн, Б.Осор нар “Монгол үсгийн дүрмийн толь” гэх мэт толь бичгүүд удаа дараа гарсан нь бичих зүй тогтол, уг бүрийн бичлэгийг үндэстэй тогтооход тодорхой үүрэг гүйцэтгэсэн юм. Гэвч эрдэмтэн судлаачдын үзэл бодол, хандлага чиглэл өөр өөр байдгаас зөв бичих дүрмийн толиудад зөрүүтэй бичсэн үг цөөнгүй бий.

Эдүгээ бидний даган мөрдөж байгаа кирил үсгийн зөв бичих дүрмийг анх боловсруулахдаа тухайн үеийнхээ хэл шинжлэлийн ололт амжилтад тулгуурлан халх аялгууны авианы бүрэлдэхүүн, үгийн бүтэц, хэл зүйн хэлбэр зэргийг нэлээд нарийн тусгажээ. Хэдий тийм боловч кирил үсгийн зөв бичих дүрмийг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай болохыг уг дүрмийг боловсруулсан академич Ц.Дамдинсүрэн өөрөө “Бид нэгмөсөн бүрэн боловсorsон сайн дүрмийг зохиож чадахгүй тул алхам алхмаар шат ахиулсаар хожим бүр сайн дүрэмтэй болж чадна гээж найдаж байна. Энэ удаагийн боловсруулсан дүрэмд дутуу дулим зүйл үлэмжсхэн байгаа” (1959:10) хэмээн хүлээн зөвшөөрсөн байдал.

Үсэг бичгээ боловсронгуй болгож, зөв бичих дүрмээ хэрхэн засан сайжруулах тухайд эрдэмтэн судлаачдын үзэл бодол, санал дүгнэлтийг дараах байдлаар ялган үзэж болмоор байна. Үүнд:

- a. Эрдэмтэн Ш.Лувсанвандан, Я.Цэвэл, Н.Эрдэнэтогтох, Э.Вандуй, Ш.Барайшир (1959), Д.Төмөртогоо (2009) нар зөв бичих дүрмийн зарчмын талаарх судалгаа шинжилгээндээ үг зүй, авиа зүйн зарчмыг голлон баримталж, шаардлагатай үед түүхэн уламжлалын болон бэлгэ тэмдгийн зарчмыг харгалzan үзэх хэрэгтэйн дээр ингэснээрээ угийн язгуур, үндэс ихэнх тохиолдолд эвдрэхгүй болохыг дурдсан байна.
- b. Ц.Дамдинсүрэн (1957), Ш.Лувсанвандан, Я.Цэвэл, Ж.Надмид (1959) нарын цагаан толгойн бүрэлдэхүүний талаарх санал дүгнэлтээс хараад кирил монгол бичгийн цагаан толгойд я-ийн төрлийн 4 үсгийг латин үсгээр орлуулж, хатуугийн тэмдэг /ь/-ийг бүр хасаад, зөвлний тэмдэг /ь/-ийг /и/-ээр солих нь зүйтэй юм гэсэн нийтлэг дүгнэлт ажиглагдахаас гадна сүүлийн үед ч зарим эрдэмтэд (Батзаяа, 2009) энэ саналыг дэмжиж байгаа явдал бий.
- c. Ш.Лувсанвандан, Чингэлтэй (1959) нарын олон эрдэмтэн гээгдэх болон шилжих эгшгийн дүрмийг хүчингүй болгож, угийн үндэс, дагаврын эгшгийг тогтвортой байлгах талаар дүрэмдээ тусгахыг өгүүлсэн байdag.
- d. "Эгшигт долоо, заримдаг ес гэдэг нь зохиомол дүрэм юм. Монгол хэлний авиа зүйн хуулиар нэг угэнд хоёр, гурван гийгүүлэгч эгшиггүйгээр ордоггүй. Гэтэл одоогийн дүрэмд энэ хуулийг хэтэрхий гүйвуулж, нэг доор хэдэн гийгүүлэгч ордог болжээ" (Э.Вандуй) гэх мэтээр эгшигт долоо, заримдаг есөн гийгүүлэгч, балархай эгшгийн дүрмийг харгалзахгүй хэрэглэх дүрэмтэй больё гэсэн дүгнэлтэй олон эрдэмтэн санал нэгдсэн байdag.
- e. Угийн бүтцийн талаарх акад. Б.Ринчений "Угийн үндэс, дагаврыг ялан мэдэхгүйгээр зохиосон дүрэм маань бага, дунд сургуулийн хэлний програмтай мөргөлдөж эхэлсэн нь цаашид хэлний шинжслэлийг хэрэгсэхгүй, угийн бүтцийг мэдэхгүй хэвээр нь дэлгэрүүлбэл улам чих зөрчил гарах болно" (1959) гэсэн саналыг акад. Ш.Лувсанвандан, А.Лувсандэндэв тэргүүтэй олон эрдэмтэн дэмжин сайшаасан байdag.

Өдгөө бүх нийтээр хэрэглэж буй кирил бичгийн нэг л дүрэм байdag. Энэ нь 1983 онд хэвлэгдсэн Ц.Дамдинсүрэн, Б.Осор нарын "Монгол үсгийн дүрмийн толь"-д хавсаргасан дүрэм бөгөөд уг дүрэм нь бүр 1951 онд Ц.Дамдинсүрэн гуай Я.Цэвэлтэй хамтран бичсэн "Үсгийн дүрмийн зөв бичих толь"-ийн бараг тэр чигээрх хуулбар нь байdag. Энэ тухай толийнхoo оршилд "...Бид энэ толь бичигтээ Монгол үсгийн товч дүрмийг хавсаргав. Энэ бол чухамдаа 1951 онд Ц.Дамдинсүрэн, Я.Цэвэл нарын "Үсгийн дүрмийн зөв бичих толь"-д хавсаргасан дүрмийг бараг хэвээр нь хуулж бичсэн билээ. Зөвхөн 1951 онд товч дүрэмд тодорхойгүй бүрхэг зүйлийг тодруулсан, орхигдсон зүйлийг нэмсэн зэрэг бага сага засварыг оруулав..." (Дамдинсүрэн, Осор, 1983:7) гэжээ. Өөрөөр хэлбэл, анх кирил үсэг аваад л үйлчилж эхэлсэн дүрэм бараг хэвээрээ юм. Ц.Дамдинсүрэн нарын "Монгол үсгийн дүрмийн толь" (1983)-д хавсаргасан дүрэм нь 64 зүйл, нийт 133 дүрмээс бүрдэх 24 нүүр (405-429-р т.) бичвэр юм. Дүрмийн зүйлүүдэд 10 гаруй гажилт гэж нэрлэсэн зүйл бий. (408-р талын §9, 410-р талын §16-18, 413-р талын §28, 416-р талын §38, 417-р талын §41, 422-р талын §5)

Сүүлийн үед эх хэлээрээ ярьж, бичих соёл доройтох боллоо хэмээн ярилцдаг болсон нь үнэний хувьтай бөгөөд түүний нэг гол шижим нь 1983 онд хэвлэгдсэн "Монгол үсгийн дүрмийн толь"-д хавсаргасан дүрмийг баримтлах зарчим алдагдаж, ялангуяа олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нэвтрэч байгаа бичвэрт уг үзэгдэл түгээмэл болсон зэрэг нөхцөл байдлыг харгалzan, кирил үсгийн зөв бичих дүрмийн журамласан толийг найруулан боловсруулж, бүх нийтээр хуульчлан мөрдөх асуудал тулгамдаж ирсэн байна. Үүнтэй уялдуулан дараах зүйлийг тэмдэглэх нь зүйтэй гэж үзэж байна. Үнд:

Нэг. Төрийн хэлний зөвлөл, БСШУЯ, МУБИС-ийн Монгол судлалын сургууль, МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтдийн дунд “Монгол хэлний зөв бичих дүрмийг боловсронгуй болгох мэргэжлийн зөвлөгөөн”-ийг зохион байгуулсан бөгөөд тус зөвлөгөөнөөр кирил бичгийн зөв бичих дүрэм болоод олон хувилбараар бичдэг угсийг нэг мөр болгон оноон тогтоох асуудлыг хэлэлцсэн байна. 2011 оны 10 сарын 05-ны өдрийн “Кирил бичгийн бичлэгийн стандарт тогтоох тухай” Төрийн хэлний зөвлөлийн 01 дугаар тогтоолоор зөрүү бичлэгтэй 622 үгийг монгол болон гадаад хэлний уг гэсэн хоёр бүлэгт хуваан, хувилбар жагсаалтыг гарган, тогтсон нэг бичлэгтэй болгон журамлажээ. Уг тогтоолын 1-р хавсралт (Олон хувилбар бичлэгтэй монгол угсийг журамласан жагсаалт)-аар 385 үг, 2-р хавсралт (Бичлэгийг нэг мөр болгосон гадаад хэлний уг)-аар 200 үг, 3-р хавсралт (Монголоор орчуулан хэрэглэх гадаад хэлний угс)-аар 31 үгийг нэг мөр болгон цэгцэлж жигдэлсэн байна.

2011 онд журамласан 622 үгийн ихэнх нь 1983 онд хэвлэгдсэн Ц.Дамдинсүрэн, Б.Осор нарын “Монгол үсгийн дүрмийн толь”-д цэгцэлж журамласан угс байна. Зарим угийг юуны учир ингэж бичих нь зөв болохыг тодруулья. Үүнд:

- “дэгдээхий/ дэгдээхэй, эрвээхий/ эрвээхэй” гэсэн хувилбарыг “дэгдээхий, эрвээхий” гэж журамласан. Учир нь, монгол бичигт “дэлхэй”, “мэнхэй” гэж бичдэг ч кирил бичигт “дэлхий”, “мэлхий” гэх мэтээр буулгаж нэг мөр болсон атлаа яг адил бүтэц, авианы тогтолцоо бүхий “эрвээхий, дэгдээхий” хоёрыг л “хэй”-тэй бичээд сурсныг Ц.Дамдинсүрэн, Б.Осор нар 1983 оны тольдоо зөв болгосон байдаг.
- “байцаа/байцаай” гэсэн хувилбар бичлэгийг “байцаай” гэж журамласан. Учир нь, шалгах, асуух утгатай “байцаа-“ хэмээх үйл угээс ялгасан бөгөөд “байцаай” нь хятад уг (“бай”-цагаан, “цай”-ногоо гэсэн утгатай). Иймд ижил уг үүсэхээс зайлсхийж угийн гарлыг нь баримтлан “байцаай” гэж бичнэ.
- “шавж/ шавъж” гэсэн хувилбар бичлэгийг “шавж” гэж журамласан. Учир нь, угийн гарлынхаа хувьд ч монгол хэлний “шавах” гэсэн үгнээс гаралтай бөгөөд монгол бичгээр шавжийг “шибажи” хэмээн бичдэг. Мөн монгол бичгээр “шавах” гэдгийг “шибаху” хэмээн бичсэнээс шавж хэмээн бичих нь зөв болох нь тодорхой харагдана.
- “бүжин/ бөжин” гэсэн хувилбар бичлэгийг “бөжин” гэж журамласан. Учир нь, “бүжин” гэвэл язгуур нь бүжиглэх, бүжих гэсэн утгатай болно. Гэтэл “бөжин”-г монгол бичигт “бөжүн” гэж бичнэ, “бөндгөр, бөөрөнхий” гэсэн “бө-“ язгуураас гаралтай.
- “дараах/дараах” гэсэн хувилбарыг “дараах” гэж журамласан. Учир нь, эр, эм угийн алинд ч хамааруулах “-х” дагаврыг зөөлрүүлэхгүйгээр “и” ба “ь”-гүй бичнэ. (дараа+x=дараах)
- 2011 оны “Кирил бичгийн бичлэгийн стандарт тогтоох тухай” тогтоолын 1-р хавсралтаар журамласан 385 үгийг 1983 онд хэвлэгдсэн Ц.Дамдинсүрэн, Б.Осор нарын “Монгол үсгийн дүрмийн толь”-д орсон бичлэгтэй нь харьцуулан үзэхэд, зөрүүтэй 48 үг, шинээр нэмэгдэж орсон 22 үг, утга ялгаж оруулсан 7 үг (вандан, төлөг, хөлөг, хөхүүлэх, мурий, цустах, цэцэн) байна. Үүнд:

a. 2017 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 163 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Ерөнхий боловсролын сургуулийн сурх бичигт орсон зөв бичих дүрмийн эргэлзээтэй бичигддэг 22 үгийг “Үсгийн дүрмийн журамласан толь” бүтээх ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцсэн бөгөөд дээр дурдсан зөрүүтэй угсээс 13 үгийг нь дараах байдлаар тогтжээ.

1983 оны Үсгийн дүрмийн тольд	2011 оны журамласан 700 үгийн жагсаалтад	Үндэслэл
-------------------------------	--	----------

цээж	чээж	1983 оны Усгийн дүрмийн толийг баримтлан, халх аман аялгууны дуудлагад ойртуулан “цээж” гэж бичихээр тогтжээ.
цагираг	цагариг	Аман дуудлагад нь ойртуулж тогтсон байна.
төвөг	түвэг	1983 оны Усгийн дүрмийн толийг баримтлан тогтжээ.
гариг	гараг	
төвд	төвөд	Түүхэн уламжлалын зарчмыг баримтлан тогтсон.
иш	эш(онол), иш (хүрзний)	Утга ялгах зарчмаар тогтжээ.
билэг	билиг	Бэлгэ тэмдгийн зарчмыг баримтлан “оюун билиг” гэж тогтсон байна.
билэгдэл	бэлгэдэл	Бэлгэ тэмдгийн зарчмаар “бэлгэдэл” гэж бичихээр тогтжээ.
гуалиг	гоолиг	Үгийн үндэс нь “гоо” учраас “гоолиг” гэж тогтсон бөгөөд “-лиг” нь олон дуудлагатай тул аман аялгууг баримтлахаар болжээ. Жишээ нь: баялаг, сүрлэг гэх мэт.
ургуу	ургуу (газар), -руу(хот)	Эгшиг, гийгүүлэгч зохицох ёсыг баримталж бичнэ. “руу, рүү, луу, лүү” гээн дөрвөн хувилбартай нөхцөл байна.
олонтаа	олонтоо	Эгшиг зохицох ёсыг баримтлан “олонтоо” гэж тогтжээ. (олонтоо, дөрвөнтөө, дөчинтөө, арвантаа)
авахуул	авхуул	Ав- гэдэг үндсэн дээр үйлдүүлэх хэвийн дагавар залгахад дуудлагаараа халхалж орсон гийгүүлэгч авиа “х” сонсодгох тул үйлт нэрийн “х” гэж үзэхгүй.
эмхтгэл, номхтгох, цомхтгол	эмхэтгэл, номхотгох, цомхотгол	2011 оны журамласан үгийн жагсаалтаар тогтжээ. (эмхэтгэл, цомхтгол, номхтгол)

- “цээж” гэдэг үгийн тухайд, монгол бичигт ts, tš хоёр авиаг адилхан ć үсгээр тэмдэглэдэг боловч монгол хэлний нутгийн аялгуунуудад “ц, ч” аль алинаар нь сольж дуудах явдал бий. Гэвч орчин цагийн монгол хэлний төв аялгуунд энэ үгийг “цээж” хэмээн хэвшсэний улмаас “чээж” гэж бичихээр тогтсон хэдий ч өнөөг хүртэл олон нийтийн дэмжлэг авч чадахгүй байна.
- “эмхтгэл” гэсэн энэ хэлбэр “с, х-ийн дараа т, ч эгшигтгүй орж болно” гэсэн дүрэмд нийцэж байгаа ч гэсэн нэг дор олон гийгүүлэгч оруулж бичих нь үгийг дуудах, бичих талаас зохистой хэлбэр биш гэж үзээд х, т хоёрын дунд эгшиг жийрэглэж бичье гэсэн санаалд хүрсэн байж болох юм. Гэвч уг хэлбэрийг нягталж үзэх бас нэг боломж байгаа юм. Юу вэ гэвэл, с, х-ийн дараа т, ч эгшигтгүй бичигдэх дүрэмд хамааруулахгүйгээр уг үгийн бүтцийг нягталж үзнэ гэсэн үг юм. Тодруулбал, “эмх+д=эмхэд (Заримдаг гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгч ороход заавал эгшигтэй бичигдэнэ); эмхэд+гэ=эмхэтгэ (“д” гийгүүлэгчээр төгссөн үгэнд бусдаар үйлдүүлэх хэвийн “-гэ” дагавар залгахад “д” авиа нь “т” болж ондоошсон. Жишээ нь: бэлд+гэ=бэлтгэ) Тийм учраас бидний санаад шинээр гарах зөв бичгийн дүрмийн тольд уг хэлбэрийг зөв бичгийн дүрмийн “с, х-ийн дараа т, ч эгшигтгүй орж болно” гэсэн дүрэмд хамааруулахаасаа илүү энэхүү бүтцийн зарчмыг харгалзвал илүү ойлгомжтой зохистой хэлбэр болохоор байна.

1983 оны “Усгийн дүрмийн толь”-д “жижгэрэх” гэснийг 2011 оны журамласан үгийн жагсаалтад “жижгирэх” гэсэн хувилбараар оруулжээ. “жижиг+p+x” гэсэн бүтэцтэй үг. Гийгүүлэгчээр төгссөн үгэн дээр гийгүүлэгчээс бүтсэн залгавар залгахад эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гээгдэх бөгөөд эгшигт гийгүүлэгч аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй байна гэсэн дүрмийн шаардлагаар “р” өмнөө эгшигтэй бичигдэнэ. Гагцхүү г, р хоёрын дунд ямар балархай эгшиг бичих вэ гэдэг л асуудал. “Үгийн дунд “ж, ч, ш” гийгүүлэгчийн дараа эгшиг бичих шаардлага гарвал “и”-ээс өөр эгшиг бичихгүй” гэсэн дүрэм байdag. Жишээ нь: бич+т=бичиг, хашиг+ж=хашиж гэх мэт. Гэтэл энэ үгэнд энэ дүрэм тохирохгүй. Тэгэхээр 1983 оны Усгийн дүрмийн толийг баримтлан, “жижгэрэх” гэж журамлах ёстой байсан нь тодорхой байна.

6. 2011 оны “Кирил бичгийн бичлэгийн стандарт тогтоох тухай” тогтоолын 1-р хавсралтад Ц.Дамдинсүрэн, Б.Осор нарын “Усгийн дүрмийн толь”(1983)-д ороогүй 22 үгийг шинээр нэмж оруулсан байна. Үүнд: *гайширал, даяаршил, даяарчлал, дүйчин, голдрил, гэгээлэг, оюунлаг, гэр лүү, илаарыших, өнтэй, сайх, хунтайж, нэг мөр, маань (тэр маань) маани (унших), нил (цэцэг) нэл (бүхэлдээ), хөдлөнги, хөшиг, элэн (халин), томчууд, томчуул зэрэг үгийг оруулжээ.*

Хоёр. Кирил үсгийн бичлэг, дуудлагыг журамласан толь бичгийг Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс гаргахаар болсон байна. “Журамласан толь” бичиг гарах хүртэл хүмүүсийн дунд эргэлзээ төрүүлсэн энэ мэт зарим асуудлыг цэгцлэх үүднээс Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2016 оны есдүгээр сарын 06-ны өдрийн 05 тоот тогтоолд Ц.Дамдинсүрэн, Б.Осор нарын 1983 онд гаргасан “Монгол үсгийн дүрмийн толь”, түүнд хавсаргасан “Монгол үсгийн дүрэм”-ийг баталгаажуулан дагаж, мөрдөхөөр тусгажээ. Ц.Дамдинсүрэн, Б.Осор нарын 1983 оны “Монгол үсгийн дүрмийн толь” 18 мянган толгой үтгэй. Гэтэл 1983 оноос хойш гэхэд л монгол хэлний үгийн санд маш олон үг шинээр бий болж, бас нэлээд үг гадаад хэлнээс орсон билээ. Иймд одоо эмхэтгэж буй толийн толгой үгийг нэмэх шаардлага зайлшгүй тулгарч байна. Энэ мэт учир байдлыг харгалзан, Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс эрхлэн гаргах журамласан толийг боловсруулж байгаа арга зарчмыг танилцуулахын хамт зөв бичих дүрмийн тольд нэг мөр болгон журамлах үгийн талаарх саналыг Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн ЕБС-ийн монгол хэл, уран зохиолын багш нараас авсанбайна. Мөн манай улстай дипломат харилцаа тогтоосон гадаадын улс орны бүтэн нэр, товч нэр, нийслэлийн нэрийг хэрхэн бичих саналыг ГХЯ-наас тус тус албан ёсоор авсан байна. Үүнтэй уялдуулан Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албаны дарга Н.Нарангэрэл сэтгүүлчид өгсөн ярилцлагадаа “Журамласан толь” бичигт дуудлага болон бичлэгийн зөрүүтэй 48 үг, хэрэглээнд өргөн хэрэглэгддэг хэрнээ өмнөх толь бичигт оруулаагүй үлдсэн нэлээд хэдэн үгийг шинээр оруулахын зэрэгцээ уг журамласан толь цаасан хувилбараас гадна орчин үеийн хэрэгцээнд нийцүүлэн гар утасны апликэйши, цахим толийн сонголттойгоор нийтийн хүртээл болгох талаар өгүүлжээ.

Өнөөдөр бид 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан “Монгол хэлний тухай” хуулийн дагуу бүх албан хэрэг, бичгийг кирил үсгээр хөтөлж байна. Ц.Дамдинсүрэн нарын “Монгол үсгийн дүрмийн толь” (1983)-д хавсаргасан дүрэм нь 64 зүйл, нийт 133 дүрмээс бүрдэх 24 нүүр (405-429-р т.) бичвэр юм. Дүрмийн зүйлүүдэд 10 гаруй гажилт гэж нэрлэсэн зүйл бий. (408-р талын §9, 410-р талын §16-18, 413-р талын §28, 416-р талын §38, 417-р талын §41, 422-р талын §5)

Зөв бичгийн дүрэм гэдэг бол журамлан тогтоосон стандарт ч мөн, тогтолцоо ч мөн. Гэтэл энэ байдал Ц.Дамдинсүрэн нарын “Монгол үсгийн дүрмийн толь”, түүнд хавсаргасан дүрмийн зарим хэсэгт алдагдсан байна. Өөрөөр хэлбэл, уг дүрэмд авиа үсэг, үе бүтээвэр, хэлэхүйн мөчлөг зогсоц, өгүүлбэр зэргийн зааг ялгаа, уялдаа холбооны тэнцвэрийг тууштай эс барьснаас зүйл зүйлийн дүрмийн учирлал, цуглуулга мэт болсон нь тухайн цаг үеийн манай хэлшинжлэлийн онол, аргазүйн ерөнхий түвшинтэй холбоотой байсан болов уу гэж үзэх учир бас бий. Иймд уялдаа холбоо, харилцан хамаарлаар нь кирил үсгийн зөв бичгийн дүрмийг

- I.
 - 1. Эгшиг үсгийн дүрэм
 - 2. Гийгүүлэгч үсгийн дүрэм
 - 3. Тэмдэг үсгийн дүрэм
- II.
 - 4. Үгийн утгат хэсэг (бүтээвэр)-ийг бичих дүрэм
 - 5. Үеэр тасалж, мөр шилжүүлэх дүрэм
 - 6. Үг хурааж товчлон бичих дүрэм

III. 7. Цэг, тэмдгийн дүрэм

8. Том үсгээр бичих дүрэм

хэмээн төрөлжүүлэн ялгавал хэрэглэхэд хялбар дөтөөс гадна монгол үгийн бүтцийн зүй тогтлыг ухаарахад тустай хэмээн санана. Тодруулбал, бидний тогтвортой мөрдөж байгаа Ц.Дамдинсүрэн нарын “Монгол үсгийн дурмийн толь”, түүнд хавсаргасан дурмийг хэрэглэхэд бидний саях өгүүлсэн саналыг тусгавал уг толины зарчимд илүү нийцэж, түүнийг хялбар дөт, ойлгомжтойгоор зохиомжлох боломж байна гэж хэлэх гэснийх юм. Кирил үсгийн зөв бичих дүрэм гарснаас хойш монгол хэлний зарим асуудлын учир холбогдлыг судалгааны үр дүнгээр нэгэнт тогтоон тодорхойлж, харгалзах нэр томьёог нь өөрчлөн, бүх шатны сургуулийн монгол хэлний сурх бичигт нэгэнт хэрэглэдэг болсон учраас шинээр боловсруулж, журамлан хэрэглэх дүрэм, толь бичигт түүнийг тусгах нь зүйтэй хэмээн үзэж байна. Эрдэмтэн Ц.Оюун “Зөв бичгийн дурмийн бүтэц тогтолцоо ба шинэчлэл (кирил үсгийн дурмийн жишээн дээр)” илтгэлдээ авиа зүйд холбогдолтой, уг зүйд холбогдолтой, өгүүлбэр зүйд холбогдолтой дүрэм (Оюун, 2017), Д.Боролзой, Г.Буяントогох нар “Нийтээр эзэмших монгол хэл” бүтээлдээ 1. Эгшиг үсгийн дүрэм, 2. Гийгүүлэгч үсгийн дүрэм, 3. Тэмдэг үсгийн дүрэм, 4. Зарим дагавар, нөхцөл, залгаврыг зөв бичих дүрэм, 5. Зарим тийн ялгалын нөхцөлийг зөв бичих дүрэм, 6. Харь хэлний үгийг зөв бичих дүрэм, 7. Цэг тэмдгийн дүрэм, 8. Том үсгээр бичих дүрэм, 9. Үеэр тасалж, мөр шилжүүлэх дүрэм, 10. Уг хурааж, товчлон бичих дүрэм гэж тулгуур дурмийг ялгажээ (Боролзой, Буяントогох нар, 2017). Энэ бүхнээс үзэхэд, кирил үсгийн зөв бичих дурмийн өдий хүртэл дагаж мөрдсөн үндсэн зарчмыг хэвээр хадгалж, бүтэц, хэв шинжийн онцлогийг харгалzan боловсронгуй болгохын сацуу бүх нийтээр чанд мөрддөг болгон хэвшүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Монгол Улсын Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс эрхлэн гаргах журамласан толь нийтийн хүртээл болсноор дараах хэдэн асуудалд хариу өгч, мөн монгол хэлшинжлэлийн хөгжилд ахиц дэвшил болох төдийгүй Монгол улс, монгол иргэд, монгол хэлийг сурч буй гадаадын хүмүүс, монголоор ном зохиол уншин туурвигч гадаадын монгол судлаачдын боловсрол мэдлэгт ихээхэн ач тустай үйлс болох юм. Үүнд:

1. “Монгол хэлний тухай” хуулийн харгалзах заалтыг нийтээр мөрдөн хэвшүүлэх;
2. Зарим үгийг ямар хэлбэрээр бичих талаар үндэслэлтэй, үндэслэлгүй марган цэцэрхэх хандлага зогсож, нэгэнт журамласан толийг бүх хүн жигд ёсчлон мөрдөх;
3. Зөв бичих дурмийн уг толь цаасан болон цахим хувилбараар олны хүртээл болох гэж байгаа нь монгол хэлшинжлэлийн зарим салбарт, ялангуяа цахим хэлшинжлэлд ахиц гарах нэг таатай боломж бий болж хэрэгжих;
4. Эх орондоо болон гадаад улсад ажиллаж, сурч буй хүүхэд багачууд, оюутан залуус нийт иргэдийн эх хэлээ эрхэмлэх, хайлрах, эзэмших, соёл боловсрол жигдрэн дээшлэхэд чухал ач холбогдолтой ажил болно гэж бид үзэж байна.

Abstract

In this paper, the author analyzes the basic concept of Cyrillic Mongolian orthography which is the official writing system in Mongolia. Not only proposals of researchers' to improve it, but also problems faced by them while complying with orthographic rules and decisions how to resolve some issues will be presented in this work.

The dictionary compiled by the National Council on Language Policy of Mongolia provides answers to questions concerning the Mongolian Cyrillic orthography. The dictionary is significant for the development of the Mongolian language. Not only does it serve as the source of knowledge and education for Mongolians, but it will also be of utmost importance to the foreign learners of the Mongolian language. We consider it fundamental:

1. To follow the provisions of the Mongolian language law;
2. To pursue the orthography proposed in the dictionary;
3. The dictionary will be available in both hard and online (electronic) versions, which will enable us to make progress in the development of computational linguistics in Mongolia by optimizing modern technology;
4. It is vital for thousands of citizens, children and students who live and study in their homes or abroad to respect, love, learn and develop their mother tongue.

Номзүй

Барайшир Ш. Усэг бичгээ улам сайн болгохын төлөө. Уб., 1959.

Батзаяа Г. Кирил, монгол бичгийн зөв бичих дүрмийн харьцуулал. Кирилжин бичгийн зөв бичих дүрмийн асуудалд. Уб., 2009.

Боролзой Д., Буянтогтох Г. нар. Нийтээр эзэмших монгол хэл. Уб., 2017, х.7-42.

Далхжав Х., Цэрэнчимэд Ц. Зөв бичих зүйн толь бичиг. Уб., 1974.

Дамдинсүрэн Ц., Цэвэл Я. Усгийн дүрмийн зөв бичих толь. Уб., 1951.

Дамдинсүрэн Ц. Усгээ өөрчлөхгүй дүрмээ сайжруулья. Үнэн, №49. Уб., 1957.2.28

Дамдинсүрэн Ц. Монгол хэл бичгийн зарим асуудал. Уб., 1959.

Дамдинсүрэн Ц., Осор Б. Монгол усгийн дүрмийн толь. Уб., 1983.

Мөөмөө С. Зөв бичих дүрмийн толь. Уб., 1962.

Оюун Ц. Зөв бичгийн дүрмийн бүтэц тогтолцоо ба шинэчлэл (кирил усгийн дүрмийн жишээн дээр). Монгол улс ба тогтвортой хөгжил I. Уб., 2017, х.139-145.

Төмөртогоо Д. Кирил усгийн зөв бичих дүрмийг засан сайжруулах шаардлага. Кирилжин бичгийн зөв бичих дүрмийн асуудалд. Уб., 2009.